

ИНФЛЯЦИЙН ХҮЛЭЭЛТ

ТҮҮВЭР СУДАЛГААНЫ ТАЙЛАН
2017 оны II улирал



МОНГОЛБАНК



ИРГЭД



АЖ АХУЙ НЭГЖ



ШИНЖЭЭЧИД

Судалгаа Статистикийн газар,
Судалгааны хэлтэс

Энэхүү тайланд зөвхөн түүвэр судалгаанд хамрагдсан иргэд, аж ахуй нэгж болон шинжээчдийн эдийн засгийн төлөө байдлын талаарх хүлээлтийн үр дүнг нэгтгэн тайлагнасан тул Монголбанкны албан ёсны байр суурь биш болно.

ИРГЭДИЙН ИНФЛЯЦИЙН ХҮЛЭЭЛТ

1-Р БҮЛЭГ



ТҮҮВЭР СУДАЛГАА 2017 ОН

1. ИРГЭДИЙН ИНФЛЯЦИЙН ХҮЛЭЭЛТ

Инфляцийн талаарх иргэдийн хүлээлтийн түүвэр судалгааг Дэлхийн банкны “CAPI” системд суурилан 2017 оны 6 дугаар сарын 5-ны өдрөөс 16-ны өдрүүдэд Улаанбаатар хотын 7 дүүргийн 914 иргэнийг санамсаргүй түүврийн аргаар сонгон судалгааг гүйцэтгэлээ. Түүвэр судалгаанаас дараах гол үр дүнгүүд галаа:

- Иргэд инфляцийн түвшинг i) чанарын хариултын хувьд 2017 оны III улиралд 3.4%, 2018 оны II улиралд 4.2%; ii) тоон хариултын хувьд 2017 оны III дугаар улиралд 2.9%, 2018 оны II улиралд 4.8%; iii) мэдрэмжид суурилсан инфляцийн хүлээлтийн хувьд 2017 оны III дугаар улиралд 3.4%, 2018 оны II улиралд 8.8% байхаар тус тус хүлээж байна.
- Иргэдийн хувьд зээлийн хүү ирээдүйд бага зэрэг буурна гэж хүлээж байна;
- Иргэдийн дунд эдийн засгийн ерөнхий төлөв сайжирна гэсэн хүлээлт мэдэгдэхүйц нэмэгдлээ;
- Иргэд өрхийн санхүүгийн байдал сайжирна гэсэн хүлээлттэй байна.

1.1. Инфляцийн хүлээлт


Чиглэлийн индексээс харахад 2014 оны дунд үеэс эхлэн иргэдийн үнийн өсөлтийн талаарх хүлээлт хандлагаараа буурч ирсэн байна. Энэ удаагийн судалгааны үр дүнг 2017 оны I улирлын дүнтэй харьцуулахад үнийн өсөлтийн талаарх иргэдийн хүлээлт бага зэрэг буурчээ. Өөрөөр хэлбэл иргэдийн дунд инфляци өнөөдрийн түвшингөөс бага зэрэг өснө гэсэн хандлага давамгайлж байгааг илэрхийлж байна /Зураг 1-1/.

Иргэдийн инфляцийн хүлээлтийг олон улсын туршлагад тулгуурлан тоон болон чанарын аргачлалаар тооцооло. Чанарын хариултыг Карлсон-Паркины аргачлалд тулгуурлан тоон үзүүлэлт рүү шилжүүлж тооцоход иргэд инфляцийг 2017 оны III улиралд 3.4%, 2018 оны II улиралд 4.2%-тай байхаар хүлээж байна. Мөн иргэдийн инфляцийн хүлээлтийг тоон хариултад тулгуурлан тооцоход 2017 оны II улиралд 2.9%, 2018 оны II улиралд 4.8%-тай байна. Түүнчлэн өнгөрсөн үеийн мэдрэмжид суурилсан инфляцийн түвшин /perceived inflation/² 2017 оны III улиралд 3.4%, 2018 оны II улиралд 8.8%-тай байхаар хүлээгдэж байна /Зураг 1-2/.

Зураг 1- 1: Үнийн өсөлтийн хүлээлт /чиглэлийн индекс, 12 сарын дараа/



Зураг 1- 2: Иргэдийн инфляцийн хүлээлт /чанарын болон тоон хариултаар/



Эх сурвалж: Монголбанк, иргэдийн хүлээлтийн түүвэр судалгаа

²Монголбанкны Судалгааны Товхимол-7. “Инфляцийн хүлээлтийг тооцох арга, аргачлалыг өргөжүүлэх нь” сэдэвт судалгааны ажлаас дэлгэрэнгүйг харна уу.


Хүлээлтийн чанарын хариултаас харвал иргэдийн 54% нь ирэх 12 сард үнийн түвшин ерөнхийдөө өснө гэж үзсэн бөгөөд үүнээс 24% нь үнийн түвшин илүү хурдацтайгаар өснө (өмнөх судалгааны дүнгүүдээс мэдэгдэхүйц буурсан), 40% нь үнэ өснө гэхдээ өсөлтийн хурдац өөрчлөгдөхгүй гэж хариулжээ /Зураг 1-3/. Түүнчлэн Дэлхийн банкны таблетад суурилсан САРІ системийг нэвтрүүлснээр судалгаанд хамрагдаж байгаа иргэдийн “Мэдэхгүй” гэж хариулах хувь эрс буурсан нь судалгааны чанар нэмэгдэж байгааг илтгэх үзүүлэлт юм.

Иргэдийн инфляцийн хүлээлтийг тоон утгаар асууж, хариултуудын жигнэсэн дундаж утгыг тооцон үзэхэд инфляцийг ирэх улиралд буюу 2017 оны III улиралд 2.9%, жилийн дараа буюу 2018 оны II улиралд 4.8%-тай байхаар хүлээж байна. Өөрөөр хэлбэл иргэдийн дунд ирэх 12 сард үнийн түвшин өснө гэсэн хүлээлт давамгайлж байна /Зураг 1-4/.


Иргэд 2018 оны III улирал хүнсний бүтээгдэхүүний инфляцийг 4.6%, хүнсний бус бүтээгдэхүүний инфляцийг бага зэрэг өндөр буюу 4.8%-тай байхаар хүлээж байна /Зураг 1-5/.

Судалгаанд хамрагдсан иргэдийн 98% нь 2017 оны III улиралд инфляцийн түвшинг зорилтот түвшинд буюу 8%-аас бага байна гэж үзсэн бол 2018 оны II улиралд иргэдийн 85% нь инфляци зорилтот түвшингөөс бага байна гэж үзжээ /Зураг 1-6/.


Зураг 1- 3: Ирэх 12 сарын хугацаанд үнийн түвшин хэрхэн өөрчлөгдөх вэ?




Зураг 1- 4: Инфляцийн хүлээлтийн тархалт /тоон хариултаар/



Зураг 1- 5: Инфляцийн хүлээлтийн тархалт /хүнсний, хүнсний бус, ирэх 12 сар/



Зураг 1- 6: Инфляцийн хүлээлтийн хуримтлагдсан тархалт /тоон хариултаар/



Эх сурвалж: Монголбанк, иргэдийн хүлээлтийн түүвэр судалгаа

1.2. Эдийн засгийн өсөлт, иргэдийн орлого

Судалгаанд хамрагдсан иргэдийн дийлэнх нь ирэх 12 сарын хугацаанд эдийн засгийн байдал сайжрах төлөв ажиглагдана гэсэн эерэг хүлээлттэй байна. Засгийн газар ОУВС-гийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрт хамрагдах болсноор цаашид гадаад зээл, хөрөнгө оруулалтууд нэмэгдэх хүлээлттэй байгаагийн зэрэгцээ эдийн засагт бодлогын эерэг өөрчлөлтүүд гарна гэсэн хүлээлт нь иргэдийн дунд эдийн засгийн байдал тогтворжиж, цаашид сайжирна гэж үзэхэд нөлөөлсөн байх талтай /Зураг 1-7/.

Энэ удаагийн иргэдийн өрхийн санхүүгийн байдлын чиглэлийн индекс өмнөх судалгааны дүнгээс бага зэрэг буурсан хэдий ч иргэдийн дийлэнх нь ирэх 12 сарын хугацаанд өрхийн санхүүгийн байдал сайжирна гэсэн хүлээлттэй байна /Зураг 1-8/.

Өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнэ харьцангуй тогтвортой байж инфляци нам дор түвшинд хэвээр байгаа нь иргэдийн бодит орлогыг хэвээр хадгалагдахад нөлөөлж байна. Иргэд ирэх нэг жилийн хугацаанд эдийн засгийн ерөнхий байдал сайжрахын хирээр өрхийн санхүүгийн байдалд эерэг нөлөө үзүүлнэ гэсэн хүлээлттэй байна.


1.3. Хүүний түвшний ирээдүйн хандлага

Судалгаанд хамрагдсан иргэдийн хувьд ирэх 12 сарын хугацаанд зээлийн хүү бага зэрэг буурна гэсэн хүлээлттэй байна³.

Санал асуулгад оролцсон иргэдийн 28% нь ирэх 12 сарын хугацаанд хадгаламжийн хүү өснө гэж үзсэн бол 57% нь хэвэндээ, 16% нь хадгаламжийн хүү буурна гэж хариулжээ. Өөрөөр хэлбэл иргэд ирэх 12 сарын хугацаанд хадгаламжийн хүү өнөөгийн түвшинд байна гэж үзжээ.

³-2017 оны II улирлын “Банкны зээлийн төлөв”-ийн судалгааны үр дүнгээр ирэх 3 сарын хугацаанд том банкууд зээлийн хүүгийн түвшинг өөрчлөх сонирхолгүй байгаа бол дунд болон жижиг банкууд зээлийн хүүгээ бага зэрэг бууруулах төлөвтэй байна.

Зураг 1- 7: Ирэх 12 сарын эдийн засгийн төлөвийн талаарх хүлээлт /чиглэлийн индекс/



Зураг 1- 8: Хадгаламжийн хүүний талаарх хүлээлт /12 сард/



Тайлбар: Чиглэлийн индекс [-1;1] завсарт утгаа авна. [0;1] сайжирна, [0] хэвэндээ байна, [0;-1] муудна.

Зураг 1- 9: Зээлийн хүүний талаарх хүлээлт /ирэх 12 сард/



Эх сурвалж: Монголбанк, иргэдийн хүлээлтийн түүвэр судалгаа

АЖ АХУЙ НЭГЖИЙН ИНФЛЯЦИЙН ХҮЛЭЭЛТ

2-Р БҮЛЭГ



ТҮҮВЭР СУДАЛГАА 2017 ОН

2. Аж Ахуй Нэгжийн Инфляцийн Хүлээлт

ААН-ийн хүлээлтийн түүвэр судалгааг Дэлхийн банкны “САРГ” системд суурилан анх удаа 2017 оны 6 дугаар сарын 5-ны өдрөөс 16-ны өдрүүдэд Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй 356 бизнес эрхлэгчдээс санамсаргүй түүврийн аргаар сонгон судалгааг гүйцэтгэлээ. Түүвэр судалгаанаас дараах гол үр дүнгүүд гарлаа:

- ААН-үүд инфляцийн түвшинг чанарын хариултын хувьд 2017 оны III дугаар улиралд 1.6%, 2018 оны II улиралд 2.1% байхаар хүлээж байна.
- ААН-үүд инфляцийн түвшинг тоон хариултын хувьд 2017 оны III дугаар улиралд 3.0%, 2018 оны II улиралд 5.1% байхаар хүлээж байна.
- ААН-үүдийн 20 орчим хувь нь үйл ажиллагаагаа өргөжүүлж, шинээр ажлын байр нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна;
- Бизнес эрхлэгчид ирэх 6 сарын хугацаанд цалингийн түвшинг тогтмол байлгах хандлагатай байна;
- ААН-үүд ирэх 6 сарын хугацаанд нийт эрэлт нэмэгдэж, борлуулалтын орлого өснө гэж хүлээж байна.

2.1. Инфляцийн хүлээлт

Инфляцийн хүлээлтийн талаарх чиглэлийн индексээс харахад 2013 оны сүүл үеэс эхлэн ААН-ийн үнийн өсөлтийн талаарх хүлээлт огцом буурч, улмаар 2017 оны II улиралд үнийн түвшин буурна гэсэн муж руу ойртсон нь сүүлийн 2 жилийн хугацааны хамгийн бага утганд хүрсэн дүн юм. Өөрөөр хэлбэл бизнес эрхлэгчдийн дунд инфляци өнөөдрийн түвшинд хадгалагдана гэсэн хүлээлт давамгайлж байна /Зураг 2-1/.

Аж ахуйн нэгжүүдийн дунд инфляцийн хүлээлтийн санал асуулгыг явуулахдаа ирэх 12 сарын хугацаанд үнийн өсөлт ямар байх талаар чанарын болон тоон хариулттай асуултуудыг асууж, инфляцийн хүлээлтийн утгыг 2 ялгаатай аргачлалаар тооцон харьцуулалт хийв. Чанарын хариултыг Карлсон-Паркины аргачлалд тулгуурлан тоон үзүүлэлт рүү шилжүүлж тооцоход ААН-үүд инфляцийг 2017 оны III улиралд 1.6%, 2018 оны II улиралд 2.1%-тай байхаар хүлээж байна. Харин ААН-ийн инфляцийн хүлээлтийг тоон хариултад тулгуурлан тооцоход 2017 оны II улиралд 3.0%, 2018 оны II улиралд 5.1%-тай байна /Зураг 2-2/.


Зураг 2- 1: Үнийн өсөлтийн хүлээлт /чиглэлийн индекс, 12 сарын дараа/



Зураг 2- 2: ААН-ийн инфляцийн /чанарын ба тоон хариултаар/



Зураг 2- 3: Зураг 2-3: ААН-ийн инфляцийн хүлээлт /тархалт, тоон хариултаар/



Эх сурвалж: Монголбанк, иргэдийн хүлээлтийн түүвэр судалгаа

ААН-ийн инфляцийн хүлээлтийг тоон утгаар асууж, хариултуудын жигнэсэн дундаж утгыг тооцон үзэхэд инфляцийг ирэх улиралд 3.0%, жилийн дараа буюу 2018 оны II улиралд 5.1%-тай байхаар хүлээж байна. ААН-үүдийн дунд ирэх 12 хугацаанд үнийн түвшин өснө гэсэн хүлээлт давамгайлж байна /Зураг 2-3/.

Судалгаанд хамрагдсан ААН-ийн 99% нь 2017 оны III улиралд инфляцийн түвшинг зорилтот түвшинд буюу 8%-аас бага байна гэж үзсэн бол 2018 оны II улиралд ААН-ийн 85% нь инфляци зорилтот түвшнээс бага байна гэж хүлээж байна /Зураг 2-4/.

2.2. Зээлийн хүүний хүлээлт


Бизнес эрхлэгчдийн хувьд ирэх 12 сарын хугацаанд зээлийн хүү тогтвортой байна гэсэн хүлээлт давамгайлж байгаа боловч өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад бага зэрэг өссөн байна /Зураг 2-5/.

2.3. ААН-ийн үйл ажиллагаа

ААН-үүдийн бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлт өнгөрсөн 6 сарын хугацаанд өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад бага зэрэг буурсан үзүүлэлттэй байна. Харин ирэх 6 сарын хугацаанд ААН-үүдийн бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлт нь нэмэгдэнэ гэсэн хүлээлт огцом нэмэгджээ. Өөрөөр хэлбэл бизнес эрхлэгчид ирэх 6 сарын хугацаанд нийт эрэлт нэмэгдэж, борлуулалтын орлого өснө гэж хүлээж байна /Зураг 2-6/.

ААН-үүдийн дийлэнх буюу 84% нь ирэх 6 сарын хугацаанд компанийнхаа үйл ажиллагааг өргөжүүлэх боломж төдийлөн бага байна гэж судалгаанд оролцогчид хариулжээ. Харин бизнес эрхлэгчдийн 16% нь ирэх 6 сарын хугацаанд үйл ажиллагаагаа өргөжүүлэх төлөвлөгөөтэй байгаа бөгөөд үүний тулд банкны зээлд хамрагдах болон өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ гэж хариулсан байна.

Зураг 2- 4: ААН-ийн инфляцийн хүлээлт /хуримтлагдсан тархалт, тоон хариултаар/



Зураг 2- 5: Ирэх 12 сарын хугацаанд банкны зээлийн хүү хэрхэн өөрчлөгдөх вэ?



Зураг 2- 6: Бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлт /өнгөрсөн 6 сар болон ирэх 6 сард/



Эх сурвалж: Монголбанк, иргэдийн хүлээлтийн түүвэр судалгаа

Эдийн засгийн хүндрэлээс гарч, бизнесийн идэвхжил бага зэрэг нэмэгдсэнээр ААН-үүдийн хувьд үйл ажиллагаа нь тэлэх орон зай үүсч, улмаар ААН-үүдийн хувьд ирэх 6 сарын хугацаанд ажлын байрыг нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй байна. Харин цалингийн хувьд ирэх 6 сарын хугацаанд төдийлөн өөрчлөхгүй байх хандлагатай байна /Зураг 2-7/.

Зураг 2- 7: Ирэх 6 сарын хугацаанд ажлын байр болон цалингаа нэмэгдүүлэх эсэх



Тайлбар: Индекс [-1;1] завсарт утгаа авна. [0;1] өснө, [0] өөрчлөгдөхгүй, [0;-1] буурна



ШИНЖЭЭЧДИЙН ИНФЛЯЦИЙН ХҮЛЭЭЛТ

3-Р БҮЛЭГ



ТҮҮВЭР СУДАЛГАА 2017 ОН

3. ШИНЖЭЭЧДИЙН ИНФЛЯЦИЙН ХҮЛЭЭЛТ

Шинжээчдийн инфляцийн хүлээлтийн түүвэр судалгаанд арилжааны банкууд, санхүүгийн байгууллагын шинжээчид болон их дээд сургуулиуд, судалгааны төвүүдийн судлаачдыг хамрууллаа. Энэ удаагийн судалгаанд мэдээллийн эх сурвалжийн хамрах хүрээ, чанарыг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд **томоохон аж, ахуй нэгжүүдийн санхүүгийн шинжээч** нарыг судалгаанд хамруулан оролцуулав.

Шинжээчдийн хүлээлтийн түүвэр судалгаанд эдийн засгийн чиглэлээр мэргэшсэн нийт 23 судлаачдын инфляци, эдийн засгийн өсөлт, бодлогын хүү болон зээлийн хүүний ирэх 12 сарын таамаглалыг нэгтгэн тооцлоо. Судалгааны үр дүн дараах байдлаар харагдаж байна /Хүснэгт 3-1/.

3.1. Шинжээчдийн таамаглал

Шинжээчид инфляцийн түвшинг 2017 оны эхний улиралд 2.5%, мөн оны эцэст 4.9%, харин 2018 оны II улиралд 5.7% байхаар таамаглаж байна. Инфляцийн түвшинг 2017 оны эцэст хамгийн ихдээ 9%-д хүрнэ гэж хүлээж байгаа нь инфляцийн зорилтод түвшнээс бага зэрэг дээгүүр үзүүлэлт юм. Өнөөдрийн шинжээчдийн таамаглалыг 2017 оны 1-р улиралд явуулсан судалгааны үр дүнтэй харьцуулахад инфляцийн таамаглал дунджаар 0.6%-иар өссөн дүнтэй байна /Зураг 3-1/.

Инфляцийн таамаглалын хистограмм буюу харьцангуй давтамжаар нь авч үзвэл шинжээчдийн дунд инфляцийг 2017 оны эцэст 6.6%-д хүрнэ гэсэн хүлээлт давамгайлж байна. Энэ нь судлаачдын дунд инфляцийн түвшин ирэх хугацаанд бага зэрэг нэмэгдэнэ гэсэн хүлээлт давамгайлж байгааг илэрхийлж байна /Зураг 3-2/.

Хүснэгт 3-1 : Судалгааны товч үр дүн

Инфляцийн таамаглал			
Цаашид эцэст 4.9%	өсч оны дунджаар		[1.5%; 9.3%]-ийн интервалд таамагласан.


Мөнгөний бодлого, эдийн засгийн өсөлт

Ирэх 12 сард мөнгөний зөөлрөх	Эдийн засаг бага зэрэг сайжирна.
-------------------------------	----------------------------------

Зураг 3-1: Инфляцийн таамаглал



Зураг 3-2: Инфляцийн таамаглалын хистограмм /2017 оны эцэст/



Эх сурвалж: Монголбанк, шинжээчдийн хүлээлтийн түүвэр судалгаа.


Шинжээчид бодит ДНБ-ий өсөлтийг 2017 оны эцэст дунджаар 3.5%, ирэх 12 сарын хугацаанд 4.5%-д хүрнэ гэж хүлээж байна. Харин зарим шинжээчид 2017 оны эцэст эдийн засгийн өсөлтийг өөдрөгөөр буюу хамгийн ихдээ 7.4%-д хүрнэ гэсэн хүлээлттэй байна. 2017 оны 1-р улиралд шинжээчид бодит ДНБ-ийн өсөлтийг оны эцэст 1.7%-д хүрнэ гэж таамаглаж байсантай харьцуулахад өнөөдрийн таамаглал даруй 1.8%-иар нэмэгджээ /Зураг 3-3,4/.

Судлаачдын таамаглалын хистограмыг авч үзвэл 2017 оны эцэст бодит ДНБ-ий өсөлт 3.5%-д хүрнэ гэж нийт судлаачдын дийлэнх хувь нь таамаглаж байна.


Шинжээчид ирэх 12 сарын хугацаанд бодлогын хүү өнөөгийн түвшнээс бага зэрэг буурч 2017 оны эцэст 13.2%-д хүрнэ гэсэн хүлээлттэй байна. Өөрөөр хэлбэл, шинжээчдийн дунд ирэх 12 сарын хугацаанд Монголбанкны мөнгөний бодлого зөөлрөнө гэсэн хүлээлт давамгайлж байна. Улмаар 2018 оны 2-р улиралд бодлогын хүүг 12.6%-ийн орчимд байна гэсэн хүлээлттэй байна /Зураг 3-5,6/.

Тухайн сард олгосон зээлийн жигнэсэн дундаж хүүг шинжээчид ирэх 12 сарын хугацаанд дунджаар өнөөгийн түвшинтэй ижил буюу 19.3%-ийн орчимд хүлээж байна. Шинжээчид тухайн сард олгосон зээлийн жигнэсэн дундаж хүүг 2017 оны эцэст хамгийн ихдээ 21.5%, хамгийн багадаа 15.0%-тай байна гэсэн хүлээлттэй байна /Зураг 3-7,8/.

Зураг 3- 3: Бодит ДНБ-ий өсөлт /таамаглал/




Зураг 3- 4: Бодит ДНБ-ий өсөлт хистограм / 2017 оны эцэст/



Зураг 3- 5: Бодлогын хүү /таамаглал/




Зураг 3- 6: Бодлогын хүү хистограм /таамаглал, 2017 оны эцэст/



Зураг 3- 7: Зээлийн хүү таамаглал



Зураг 3- 8: Зээлийн хүүний хистограм /таамаглал, 2017 оны эцэст/



Эх сурвалж: Монголбанк, шинжээчдийн хүлээлтийн түүвэр судалгаа.

ДҮГНЭЛТ, ХАВСРАЛТ

4-Р БҮЛЭГ



ТҮҮВЭР СУДАЛГАА

4. ДҮГНЭЛТ

4.1.Иргэдийн инфляцийн хүлээлтийн түүвэр судалгааны дүгнэлт

Судалгааны үр дүнгээс харахад ирэх 12 сарын хугацаанд иргэдийн дунд инфляци өнөөдрийн түвшинээс өснө гэсэн хандлага давамгайлж байна. Иргэд 2018 оны 2 дугаар улиралд инфляцийг 4.2% /чанарын хариултын хувьд/, 4.8% /тоон хариултын хувьд/, 8.8% /мэдрэмжид суурилсан/ тус тус байхаар хүлээж байна.

Иргэд ирэх нэг жилийн хугацаанд эдийн засгийн ерөнхий байдал эрчимтэй сайжирч, улмаар өрхийн санхүүгийн байдалд эерэг нөлөө үзүүлнэ гэсэн хүлээлттэй байна.

4.2.Аж ахуй нэгжийн инфляцийн хүлээлтийн түүвэр судалгааны дүгнэлт

ААН-ийн инфляцийн хүлээлтийн санал асуулгын дүнгээр ААН-үүд инфляци өнөөдрийн түвшинд хадгалагдана гэж хүлээж байна. ААН-үүд 2018 оны II улиралд инфляцийг тоон хариултын хувьд 5.1% байхаар хүлээж байна.

Бизнес эрхлэгчид ирэх 6 сарын хугацаанд цалингийн түвшинг хэвээр хадгалах төлөвлөгөөтэй байгаа нь судалгаагаар харагдлаа. Түүнчлэн ААН-үүд ирэх 6 сарын хугацаанд нийт эрэлт нэмэгдэж, борлуулалтын орлого өснө гэж хүлээж байна

ААН-үүдийн 20 орчим хувьд үйл ажиллагаагаа тэлэх орон зай үүсч байгаагийн зэрэгцээ, ажлын байраа бага зэрэг нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.

4.3. Шинжээчдийн инфляцийн хүлээлтийн түүвэр судалгааны дүгнэлт

Судалгааны үр дүнгээс харахад шинжээчид инфляцийн түвшинг 2017 оны эцэст 4.9%, харин 2018 оны 6-р сард 5.7%-д хүрнэ гэж таамаглаж байна.

Ирэх 12 сарын хугацаанд мөнгөний бодлого зөөлөрч, улмаар зээлийн хүү өнөөгийн түвшнээс бага зэрэг буурч эдийн засгийн өсөлт нэмэгдэнэ гэсэн хүлээлттэй байна.




ХАВСРАЛТ 1.


Хавсралт 1.1 : Судалгаанд оролцсон иргэдийн ерөнхий мэдээлэл

Судалгаанд оролцсон нийт иргэдийн 56% нь эмэгтэй, 44% эрэгтэй бөгөөд насны байдлаар нь авч үзвэл 29% нь 18-25, 27% нь 26-35, 21% нь 36-45, 13% нь 46-55, 9% нь 56-аас дээш гэсэн насны ангилалд хамрагдаж байна.

Хавсралт 1.1-1: Хүйс




Хавсралт 1.1-2: Нас



Хавсралт 1.1-3: Боловсролын түвшин




Хавсралт 1.1-4: Сарын дундаж зардал



Эх сурвалж : Монголбанк, иргэдийн хүлээлтийн түүвэр судалгаа

ХАВСРАЛТ 1.

Хавсралт 1-2: Түүвэр судалгаа авсан газар зүйн тархалт





ХАВСРАЛТ 2.

Судалгаанд оролцсон ААН-үүдийн ерөнхий мэдээлэл

Судалгаанд хамрагдсан нийт 357 аж ахуй нэгж, байгууллагуудыг өмчлөлийн хэлбэрээр авч 151 (43%) нь хязгаарлагдмал хариуцлагатай компани, 128 (37%) нь бусад хэлбэрийн, 40 (11%) нь хувьцаат компани болон 19 (5%) нь нөхөрлөл байлаа (Хавсралт 2-1).

Хавсралт 2-1: Аж ахуй нэгжийн тоо өмчлөлөөр

Аж ахуйн нэгжийн хэлбэр	тоо	хувь
Хязгаарлагдмал хариуцлагатай компани	151	43%
Нөхөрлөл	19	5%
Хоршоо	9	3%
Хувьцаат компани	40	11%
Төрийн өмчит үйлдвэрийн газар	3	1%
Бусад	128	37%
НИЙТ ДҮН	350	100.0%

Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн салбаруудаар ангилан авч үзвэл нийт 356 ААН-ээс үйлчилгээ эрхэлдэг 45%, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхэлдэг 29%, боловсруулах үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхэлдэг 6% болон бусад төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг 12% байна (Хавсралт 2-2).


Хавсралт 2-2: Аж ахуй нэгжийн тоо / салбараар, ажилтны тоогоор/

Салбарын ангилал	Ажилчдын тоо /бүлгээр/					Бүгд
	< 10	11–19	20–49	50–100	101 <	
Хөдөө аж ахуй	0%	0%	0%	0%	1%	2%
Уул уурхай, олборлох	1%	0%	0%	0%	0%	2%
Боловсруулах үйлдвэр	2%	2%	0%	1%	1%	6%
Барилга	2%	0%	0%	0%	0%	3%
Б/Ж худалдаа	23%	4%	1%	1%	1%	29%
Үйлчилгээ	30%	7%	3%	2%	2%	45%
Тээвэр	1%	0%	0%	0%	0%	2%
Бусад	7%	3%	1%	1%	0%	12%
НИЙТ ДҮН	66.4%	16.2%	6.9%	5.1%	5.5%	100%

Эх сурвалж : Монголбанк, ААН-ийн хүлээлтийн түүвэр судалгаа


ХАВСРАЛТ 2.

Хавсралт 2-3: Түүвэр судалгаа авсан газар зүйн тархалт




ХАВСРАЛТ 3.


Хавсралт 3-1: Инфляцийн таамаглал
/2017 оны 7-р сард/




Хавсралт 3-2: Инфляцийн таамаглал
/2018 оны 6-р сард/




Хавсралт 3-3: Төгрөгийн ам.доллартай харьцах ханш /2018 оны 6-р сард/




Хавсралт 3-4: Бодит ДНБ-ийн өсөлтийн таамаглал /2018 оны 6-р сард/



Хавсралт 3-5: Бодлогын хүү /2018 оны 6-р сард/



Хавсралт 3-6: Зээлийн хүү /2018 оны 6-р сард/



Эх сурвалж : Монголбанк, шинжээчдийн хүлээлтийн түүвэр судалгаа